



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 23 өдөр

Дугаар 6/23

Дадал сум


Ш.Гангантуулд сахилгын шийтгэл
оногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.1, 123.2.1, 123.2.2, 123.3, 123.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн гэрээний 7.2.3, 8.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Соёлын төвийн дарга Ширбазарын Гангантуулд удаа дараа анхааруулан ажлын байрны тодорхойлолтонд заасан ажил үүргээ чанартай гүйцэтгэх, аливаа ажлыг цаг хугацаанд нь хариуцлагатайгаар зохион байгуулахыг сануулсаар байтал 2025 оны Улсын баяр наадмыг зохион байгуулахад нээлт, хаалтын үед төлөвлөсөн ажлуудыг зөрчих, техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаагүй зэрэг алдаа дутагдал гаргасан тул нийт ажилтан, албан хаагчдад нээлттэй сануулах хэлбэрээр сахилгын шийтгэл оногдуулсугай.

2.Сахилгын шийтгэл хүлээсэн Ш.Гангантуулд алдаа дутагдлаа залруулан, дахин давтсан тохиолдолд дараагийн шатны арга хэмжээ авахыг анхааруулан байгууллагын ашигт ажиллагаа, үр дүнг дээшлүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.МӨНХХУЯГ

010000428